

Улсын дээд шүүхийн шүүгчдийн
зөвлөгөөний 2021 оны 11 сарын 18-ны
өдрийн 11 дүгээр тогтоолын хавсралт

УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД ХЭРЭГ, НЭХЭМЖЛЭЛ, ГОМДОЛ, ХҮСЭЛТ
ХҮЛЭЭН АВАХ, ХУВААРИЛАХ БОЛОН ХЭРЭГ, МАРГААНЫГ ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ ШҮҮХ БҮРЭЛДЭХҮҮН, ШҮҮХ ХУРАЛДААН ДАРГАЛАГЧИЙГ
СУГАЛААГААР ТОМИЛОХ ЖУРАМ, ХА0014

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын дээд шүүхэд ирүүлсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг сугалаагаар томилоход Монгол Улсын шүүхийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиуд заасныг болон энэхүү журмыг баримтална.

1.2. Хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн, хуралдаан даргалагчийг сугалаагаар томилох ажиллагаа нь дараах зарчимд үндэслэсэн байна.

1.2.1. урьдчилан мэдэх боломжгүй;

1.2.2. тойрог дотор санамсаргүй тохиолдлоор;

1.2.3. ачаалал тэнцвэржүүлэх;

1.2.4. хуваарилагдсан шүүгч, шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүн нь зөвлөгөөний (танхимын) шийдвэргүйгээр өөрчлөгдөх боломжгүй;

1.2.5. хүний нөлөөллөөс ангид;

1.2.6. ил тод;

1.2.7. баримтжуулсан байх;

1.2.8. шуурхай байх;

1.3. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1. "хэрэг" гэж

1.3.1.а. хяналтын шатны шүүхэд хандаж хяналтын журмаар гаргасан гомдол прокурорын эсэргүүцэлтэй эрүү, иргэн, захиргааны хэрэг,

1.3.1.б. хяналтын журмаар гаргасан гомдол, прокурорын эсэргүүцлийг танхимын нийт шүүгчийн хуралдаанаар хянан хэлэлцэж, хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн эрүү, иргэн, захиргааны хэрэг,

1.3.1.в. шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлт, прокурорын дүгнэлттэй эрүү (цагаатгалын хэрэг), иргэн, захиргааны хэрэг,

1.3.1.г. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу зарим төрлийн маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэж гаргасан давж заалдах шатны шүүхийн шийдвэрт давж заалдах журмаар гомдол гаргасан захиргааны хэрэг,

1.3.1.д. шүүхийн харьяаллыг тогтоолгохоор Эрүүгийн хэргийн танхимд ирүүлсэн эрүүгийн хэрэг,

1.3.1.е.сахилгын хэргийн оролцогчийн гомдол, илтгэгч гишүүний эсэргүүцэлтэй сахилгын хэрэг,

1.3.1.ё.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан хуулиар анхан шатны журмаар хянан шийдвэрлүүлэхээр харьяалуулсан эрүүгийн хэргийг ойлгоно.

1.3.2.“нэхэмжлэл” гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан хуулиар анхан шатны журмаар хянан шийдвэрлүүлэхээр харьяалуулсан эрх зүйн маргааны талаарх нэхэмжлэлийг ойлгоно.

1.3.3.“гомдол” гэж

1.3.3.а.давж заалдах шатны шүүхийн магадлалд хяналтын журмаар гаргасан гомдол,

1.3.3.б.захиргааны хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрт гаргасан давж заалдах гомдлыг ойлгоно.

1.3.4.“хүсэлт” гэж

1.3.4.а.хэргийн харьяалал тогтоолгох асуудлаар,

1.3.4.б.хяналтын шатны шүүхийн тогтоолд үг, үсэг, тооны зэрэг техникийн шинжтэй алдаа гарсан бол залруулга хийлгэх тухай,

1.3.4.в.иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хууль тайлбарлуулах талаар,

1.3.4.г.улс төрийн нам үүсгэн байгуулсан болон намыг өөрчлөн байгуулах үйл ажиллагааг зогсоосны болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг бүртгүүлэх талаар гаргасан өргөдөл, хүсэлтийг ойлгоно.

1.3.5.“тойрог дотор санамсаргүй тохиолдлын аргаар” гэж тухайн тайлант оны нийт шүүгчдийн зөвлөгөөнөөр, мөн тухайн танхимын шүүгчдийн зөвлөгөөнөөр сугалаа ашиглан тогтоосон шүүгчдийн нэрсийн дараалал бүхий тойрог дотроос программ хангамж ашиглан санамсаргүй байдлаар сонгож хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хуваарилах аргыг ойлгоно.

1.3.6.“хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хуваарилахгүй байх нөхцөл” гэж шүүгчдийн зөвлөгөөнөөр тогтоосон хугацаанд шүүгч удаан хугацаагаар өвчтэй, чөлөөтэй байх, сургалтад хамрагдах зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар эзгүй (ажиллаагүй) байхыг ойлгоно.

Хоёр.Хэрэг хүлээн авах, хуваарилах

2.1.Энэ журмын 1.3.1-д заасан эрүү, иргэн, захиргааны хэргийг Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан шинжээч нь хэргийн бүрдлийг шалган хүлээн авсан даруйд тус тусын файлд ирсэн дарааллаар нь жагсаалт үүсгэн бүртгэхдээ хяналтын гомдолтой, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлттэй гэх мэтчилэнгээр тухайлсан тайлбарыг бичнэ.

2.1.1.Бүртгэсэн даруйд шүүхийн дардас даран хүлээн авсан он, сар, өдөр, цаг минут, бүртгэлийн дугаарыг тэмдэглэнэ.

2.2.Хяналтын журмаар гаргасан гомдол, эсэргүүцэлтэй эрүү, иргэн, захиргааны хэргийг тус тусын файлаас хэвлэж авсан бүртгэлээр нь долоо хоног тутам холбогдох танхимын тэргүүний туслахад хүлээлгэж өгнө.

2.2.1. Танхимын тэргүүний туслах нь хэргийг хүлээж авсан даруйд, жагсаалтын дарааллын дагуу сар, өдөр, цаг, минутаар бүртгэлийн дэвтэрт бүртгэж, танхимын дардас дарна.

2.2.2. Танхимын нийт шүүгчийн хуралдаанаас, хяналтын журмаар гаргасан гомдол, прокурорын эсэргүүцлийн дагуу тухайн хэргийг хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн даруйд танхимын тэргүүний туслах нь нэгдсэн системд оруулан хуваарилна.

2.3. Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах хүсэлт, прокурорын дүгнэлттэй иргэн, захиргаа, эрүүгийн (цагаатгалын) хэргийг Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан шинжээчээс, холбогдох танхимын тэргүүний туслах тухай бүр хүлээн авч, бүртгэсэн даруйд нэгдсэн системд оруулан хуваарилна.

2.4. Тусгай журмаар шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэрт гаргасан давж заалдах гомдолтой захиргааны хэргийг Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан шинжээчээс, Захиргааны хэргийн танхимын тэргүүний туслах тухай бүр хүлээн авч, бүртгэсэн даруйд нэгдсэн системд оруулан хуваарилна.

2.5. Хэргийг хуваарилсан даруйд танхимын тэргүүний туслах, тухайн хэрэг хуваарилагдсан шүүгчид, хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүгчид хүлээлгэн өгөх боломжгүй бол шүүгчийн туслахад бүртгэлийн дэвтэрт гарын үсэг зуруулан хүлээлгэж өгнө.

2.6. Шүүхийн сахилгын хорооны хяналтын тогтоолд гаргасан гомдол, эсэргүүцэлтэй сахилгын хэргийг Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан-шинжээч хүлээн авч, он, сар, өдөр, цаг, минутыг бүртгэж, дардас дарна.

2.6.1. Улсын дээд шүүхийн нийт шүүгчдээс сугалааны журмаар илтгэгч шүүгчийг тодруулж, түүнд хуваарилна.

2.7. Шүүхийн харьяалал тогтоолгохоор Эрүүгийн хэргийн танхимд ирүүлсэн эрүүгийн хэргийг танхимын тэргүүнд хуваарилна.

2.8. Хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн 50 ба түүнээс дээш хавтастай хэргийг тусад нь тойрог үүсгэн, журмын 2.2.2-т зааснаар хуваарилна. Хэргийг хуваарилахдаа тойргоос урьд нь хэрэг хүлээн авсан шүүгчийн нэрийг сонгогдох жагсаалтаас хасна. Харин сонгогдох шүүгчийн нэрсийн жагсаалтад 1 шүүгч үлдвэл бусад шүүгчийн нэрсийг жагсаалтад буцаан оруулж хэргийг хуваарилна.

2.9. Анхан шатны журмаар хянан шийдвэрлэх эрүүгийн хэргийг тусад нь үүсгэсэн файлд бүртгэх ба Эрүүгийн хэргийн танхимын шүүгчдээс сугалааны журмаар шүүгчид хуваарилна.

2.10. Танхимын тэргүүнд хэрэг хуваарилахдаа хэрэг хуваарилах нэгдсэн системд “нэг удаа өнжих” тохиргоог хийнэ.

2.11. Шүүгчийг гагцхүү хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан журмаар зөвшөөрөгдсөн татгалзал, эсхүл энэ журмын 1.3.6-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд тухайн танхимын шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмын дагуу хэргийг дахин хуваарилна.

2.11.1. Зөвлөгөөний шийдвэрийг үндэслэн хэргийг дахин хуваарилахдаа тухайн шүүгчийг тойргоос гарган бусад шүүгч нарт тойрог дотор санамсаргүй байдлаар хуваарилах сонголтыг нэгдсэн системд тохируулсан байна.

2.11.2.Хуульд заасан үндэслэл журмын дагуу тухайн хэргийг илтгэх шүүгч өөрчлөгдөж байгаа тохиолдолд программд өөрчилсөн үндэслэл, шийдвэрийн талаар шаардагдах өгөгдлүүдийг оруулах бөгөөд энэ талаарх баримтын хувийг программ хангамж хариуцсан ажилтанд хадгалуулж, жил бүр архивт шилжүүлнэ.

Гурав.Хяналтын журмаар гаргасан гомдол, прокурорын эсэргүүцлийг хүлээн авах, танхимын хуралдаанаар хэлэлцүүлэх

3.1.Тамгын газар нь тухайн танхимд хүлээн авсан эрүү, иргэн, захиргааны хэрэгт гаргасан хяналтын гомдол, прокурорын эсэргүүцэл, анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг танхимд ажиллаж байгаа шүүгчдийн тоогоор хувилан, энэ журмын 3.2-т заасан танхимын хуралдаан болохоос долоо хоногийн өмнө шүүгч нарт тарааж өгсөн байна. Төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарахаас бусад баримтыг албаны цахим хаягаар хүргүүлнэ.

3.2.Хяналтын журмаар гаргасан гомдол, прокурорын эсэргүүцлийг хэлэлцэх Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааныг 7-14 хоног тутамд тогтмол хуралдуулна. Тухайн танхим хуралдах 7 хоног бүрийн тогтмол гараг болон дэгээ өөрөө тогтооно.

3.3.Хяналтын журмаар гаргасан гомдол, эсэргүүцлийг хэлэлцэх танхимын нийт шүүгчийн хуралдаанд тухайн танхимд ажиллаж байгаа бүх шүүгч оролцох үүрэгтэй. Танхимын нийт шүүгчийн хуралдаанд 6-аас доошгүй шүүгч оролцсоноор хуралдааныг ирцийн хувьд хүчинтэйд тооцно. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүгч биечлэн оролцох боломжгүй бол онлайнаар оролцож болно. Хуралдааны ирц хүрээгүй бол хуралдааныг хойшлуулж, энэ талаар танхимаас тогтоол гаргана.

3.4.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн харьяалагдах танхимын нийт шүүгчийн хуралдааны ирц хуульд заасан үндэслэлээр хүрэлцэхгүй болсон тохиолдолд Ерөнхий шүүгч танхимын нийт шүүгчдийн хуралдаанд оролцоно.

Дөрөв.Улс төрийн нам үүсгэн байгуулсныг болон өөрчлөн байгуулсныг, намын үйл ажиллагаа зогсоосны болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт хүлээн авах, хуваарилах

4.1.Улс төрийн нам үүсгэн байгуулсныг болон өөрчлөн байгуулах, үйл ажиллагаа зогсоосны болон түүний мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн хүлээн авч, бүртгэх ажиллагааг Улс төрийн намын бүртгэл хөтлөх журамд заасны дагуу гүйцэтгэсний дараа Захиргааны хэргийн танхимд шилжүүлнэ.

4.2.Захиргааны хэргийн танхимын шүүгчдийн зөвлөгөөнөөс “тойрог дотор-санамсаргүй горим”-оор үүсгэсэн дарааллын дагуу тухайн хүсэлтийг шүүгчид хуваарилна.

4.3.Захиргааны хэргийн танхим Улс төрийн намын бүртгэл хөтлөх ажиллагааг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 09 дүгээр тогтоолоор баталсан “журам”-д зохицуулснаар хэрэгжүүлнэ.

Тав.Шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг томилох талаар

5.1.Хэргийг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг тухайн танхимын шүүгчдээс урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор программ сонгож томилно.

5.2.Энэ журмын 2.11-т заасан нөхцөл байдал үүссэнээс шүүх бүрэлдэхүүнд томилогдсон шүүгч, хуралдаан даргалагч тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй болсон бол танхимын шүүгчдийн зөвлөгөөний шийдвэрийг үндэслэн бүрэлдэхүүний шүүгчийг тухайн бүрэлдэхүүнд томилогдоогүй шүүгчдээс, хуралдаан даргалагчийг илтгэгч шүүгчээс бусад бүрэлдэхүүнд орсон шүүгчид дотроос сугалааны журмаар томилно.

5.3.Хуульд заасан үндэслэлээр тухайн танхимын шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд шүүх бүрэлдэхүүнд томилогдох шүүгчийг бусад танхимын шүүгчдээс сугалааны журмаар томилж оруулна.

5.4.Хуульд заасан үндэслэл, журмын дагуу бүрэлдэхүүнд орох, хуралдаан даргалагч шүүгч өөрчлөгдөж байгаа тохиолдолд энэ журмын 2.11-т заасан ажиллагааг мөн гүйцэтгэнэ.

5.5.Шүүх хуралдаан хойшилсон нь шүүх бүрэлдэхүүн өөрчлөгдөх үндэслэл болохгүй.

Зургаа.Бусад

6.1.Шүүгчийн ээлжийн амралт эхлэхээс хуанлийн 14 хоногийн өмнө хэрэг хуваарилалтыг зогсоож, ээлжийн амралт дуусахаас хуанлийн 7-14 хоногийн өмнө хэргийг энэ журамд заасны дагуу хуваарилна.

6.2.Шүүгч сургалтад хамрагдах, эрүүл мэндийн болон бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас удаан хугацааны чөлөө авсан бол тухайн чөлөөний хугацаа эхлэхээс 14 хоногийн өмнө хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хуваарилалтыг зогсоож, уг хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг энэ журамд заасны дагуу хуваарилна.

-----oOo-----